



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024
ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

АУДИТЫН КОД: СЭА-2025/31-18-ШТА-ГА

ОНХНС-ААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН 983.9 САЯ ТӨГРӨГИЙН
САНХҮҮЖИЛТ ОЛГОГДООГУЙ, МТТАТ-ЫН ОРЛОГО 434.7 САЯ ТӨГРӨГӨӨР
ТАСАРСНААС ШАЛТГААЛАН 1,418.5 САЯ ТӨГРӨГИЙН ЭХ ҮҮСВЭР ДУТУУ
БҮРДСЭН БАЙНА.

Сүхбаатар сум 2025 он



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитор Б.Наранцэцэг

Утас: 70362442 Цахим хаяг: narantsetsegb@audit.gov.mn

Аудитор Ж.Цогт

Утас: 70362442 Цахим хаяг: tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Малын тоо толгойн албан татварыг дутуу ногдуулан, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

1.1. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 983.9 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

1.2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 4 төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх?

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээний биелэлт, үр дүнг “Гэрээ дүгнэх маягт”-аар үнэлээгүй байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн 79 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй буюу төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.

2.3. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгүүд нь бүрэн ашиглалтад ороогүй байна.

Бүлэг 3. Аймаг, сумдын ЗДТГ нь онхс-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй, үр дүнг журмын дагуу нэгтгэж тайлагнаагүй байна.

3.1. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.2. Аймаг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу нэгтгэн тайлагнаж хүргүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УМС	Удирдлага мэдээллийн систем
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1. ОНХС-ийн хуваарилалт

Хүснэгт 2. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт 3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа /хувиар/

Дүрслэлийн товъёг:

Дүрслэл 1. Төлөвлөлт

Дүрслэл 2 Аймаг, сумдын ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/

Дүрслэл 3. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/

Дүрслэл 4. Удирдлагын мэдээллийн системд байршуулаагүй мэдээлэл /сая төгрөг/

Хавсралтын товъёг:

Хавсралт 1. МТТАТ-ын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаа

Хавсралт 2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 3. Автомашин, тоног төхөөрөмжийг техникийн нөхцөл, тоо хэмжээтэй тулгаж аваагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 4. Магадалшгүй ажлын хурлын тэмдэглэл үйлдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 5. Алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 6. Санхүүжилтийг гэрээ дүгнэсэн актгүйгээр олгосон төсөл, арга хэмжээний жагсаалт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан “Аудитын сэдэв батлах тухай” А107, “Аудитын жилийн төлөвлөө батлах” А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянасан, тайлагнах эсэх асуудлыг тус тус хамрууллаа.

Аудитын хамарсан хүрээ:

Аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын баримт материал болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020 “Төрийн аудит. Чанарын хяналт”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Б.Наранцэцэг, Ж.Цогт, Э.Энхбүрэн, Р.Отгонжаргал нар 2025 оны 05 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т **“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ”** гэж заасан байна.

“Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 27,768.4 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад аймаг нь 16,304.6 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээг бүрэн, 17 сум нь 25,710.2 сая төгрөгийн 257 төсөл арга хэмжээг бүрэн, 3 сум нь 2,627.2 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээг дутуу, 8 сум нь 2,097.7 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээний мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжин хэрэгжих 1,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, шинээр хэрэгжих 8,317.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 зэрэг нийт 9,340.1 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 8,209.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэх 26,261.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 274 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 22,850.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 226 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 46,721.3 сая төгрөгийн 380 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 260 төсөл, арга хэмжээ буюу 68.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 41 төсөл, арга хэмжээ буюу 10.8 хувь нь дутуу хэрэгжсэн, 79 төсөл, арга хэмжээ буюу 20.8 хувь нь огт хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ ДУТУУ НОГДУУЛАН, ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**1.1. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 983.9 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.**

1.1.1. “Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 1,239.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 27,768.4 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

1.1.2. ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрээс Сэлэнгэ аймагт хуваарилсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2¹, 59.3², Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тооцож хуваарилсан байна. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 983.9 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. ОНХС-ийн хуваарилалт

/сая төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Итгэлцүүрээр хуваарилагдах нийт дүн	АМХ-ын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМА-ын тусгай зөвшөөрлийн төлбөр	Өмнөх оны төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	Нийт дүн
1	Алтанбулаг	464.25				464.25
2	Баруунбүрэн	496.90	0.04		100.38	597.32
3	Баянгол	1,353.91	7.38	93.63	134.36	1,589.28
4	Ерөө	2,712.72		152.81	233.86	3,099.39
5	Жавхлант	233.87			44.86	278.73
6	Зүүнбүрэн	277.57			53.32	330.89
7	Мандал	2,757.15	0.40	106.84	636.80	3,501.19
8	Орхон	293.53		0.93		294.46
9	Орхонтуул	1,425.01	20.60	86.42	130.19	1,662.22
10	Сайхан	621.78	0.09	1.91	180.00	803.78
11	Сант	261.65			63.44	325.09
12	Сүхбаатар	990.26				990.26
13	Түшиг	644.28		10.63		654.91
14	Хушаат	349.06			62.54	411.60
15	Хүдэр	788.06		32.65	96.99	917.70
16	Цагааннуур	685.49			134.90	820.39
17	Шаамар	259.42		0.09	51.07	310.58
18	Аймаг ОНХС	9,732.51				9,732.51
Нийт дүн		24,347.42	28.51	485.91	1,922.71	26,784.55

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Дээрх хүснэгтээс харахад ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн 36.3 хувь буюу 9,732.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 63.7 хувь буюу 17,052.0 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан бөгөөд Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу тооцож олгосон байна.


¹ Аймаг, нийслэл нь ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах.

² Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно: 59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс; 59.3.2.хүн амын тоо; 59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

1.1.3. Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Аймгийн 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 180 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 152 дугаар тушаалд үндэслэн Аймгийн засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны А/461 дүгээр захирамжаар ОНХС-ийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

1.1.4. Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 25,835.5 сая төгрөгийг ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс, 1,932.8 сая төгрөгийг өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний урамшууллаас, 4,520.0 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, 2,567.7 сая төгрөгийг МТТАТ-ын орлогоос зэрэг нийт **34,856.0** сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. ОНХС-ийн төлөвлөлт



1.1.5. Гүйцэтгэлээр 2024 онд ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс 24,861.9 сая төгрөг, өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний урамшууллаас 1,922.7 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 433.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 26.2 сая төгрөг, МТТАТ-ын орлогоос 1,489.4 сая төгрөг зэрэг нийт **28,733.3** сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээр орлогын төлөвлөгөө **82.4** хувьтай биелсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Аймаг, сумын нэр	2024 оны ОНХНС болон улсын төсөв						2024 оны орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр										ОНХС-ийн нийт эх үүсвэр	
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1 орсон/		АМХ-ын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		АМА-ын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /Хуулийн 60.2.10/		Бусад орлого		Малын тоо толгойн албан татвар					
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц		
1	Алтанбулаг	481.1	464.3					18.9						50.0	50.0	550.0	514.3		
2	Баруунбүрэн	496.9	496.9	0.04	0.04			79.2		110.5	100.4			198.7	70.0	885.3	667.3		
3	Баянгол	1,411.6	1,353.9	7.4	7.4	93.6	93.6	148.8	96.4	134.4	134.4			239.9	130.6	2,035.7	1,816.2		
4	Ерөө	2,825.1	2,712.7			152.8	152.8	244.3	66.8	233.9	233.9			140.0	69.7	3,596.1	3,235.9		
5	Жавхлант	244.0	233.9					116.0		44.9	44.9			105.0	81.4	509.9	360.2		
6	Зүүнбүрэн	289.6	277.6					143.4		53.3	53.3			140.0	-	626.3	330.9		
7	Мандал	2,884.1	2,757.2	0.4	0.4	106.8	106.8	557.5	216.5	636.8	636.8			280.0	63.5	4,465.6	3,781.2		
8	Орхон	295.5	293.5			0.9	0.9	31.7	37.0					166.0	149.0	494.1	480.5		
9	Орхонтуул	1,485.3	1,425.0	20.6	20.6	86.4	86.4	170.0		130.2	130.2		9.1	331.0	166.6	2,223.5	1,837.9		
10	Сайхан	650.9	621.8	0.1	0.1	1.9	1.9	266.1		180.0	180.0			150.0	108.1	1,249.0	911.9		
11	Сант	273.4	261.7					126.2	15.8	63.4	63.4			134.0	76.7	597.1	417.6		
12	Сүхбаатар	1,026.2	990.3					178.8					7.0	31.3	9.3	1,236.2	1,006.6		
13	Түшиг	668.0	644.3			10.6	10.6	171.7						62.2	41.5	912.5	696.4		
14	Хушаат	349.1	349.1					102.0		62.5	62.5			159.2	219.3	672.7	630.9		
15	Хүдэр	821.4	788.1			32.7	32.7	222.9		97.0	97.0			37.0	36.0	1,210.9	953.7		
16	Цагааннуур	715.2	685.5					525.2	0.6	134.9	134.9			320.2	181.6	1,695.5	1,002.6		
17	Шаамар	275.3	259.4			0.1	0.1	40.7		51.1	51.1			23.3	36.0	390.4	346.6		
18	Аймгийн ОНХС	10,128.5	9,732.5					1,376.8				10.1				11,505.3	9,742.7		
	Дүн	25,321.1	24,347.4	28.5	28.5	485.9	485.9	4,520.0	433.1	1,932.8	1,922.7	-	26.2	2,567.7	1,489.4	34,856.0	28,733.3		

Эх сурвалж: МУ-ын 2024 оны төсвийн тухай хууль, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ОНХС-ийн харилцах дансны хууль

1.1.6. ОНХС-ийн орлогын бүрэлдэхүүн хэсэг болох МТТАТ-ын орлогыг 2024 онд 17 сумын хэмжээнд 2,567.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,132.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, биелэлт **83.1** хувьтай буюу **434.8** сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1.7. 2024 онд ногдуулах МТТАТ-ын дүнг мал тооллогын статистик мэдээ болон сумдын ИТХ-ын тогтоолтой тулган баталгаажуулахад 8 сум 141.7 сая төгрөгөөр дутуу ногдуулсан, мөн 10 сум МТТАТ-ын төвлөрсөн орлогыг ОНХС-ын дансанд 643.5 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ": 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого ...", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.1.8. МТТАТ-ын орлогын төлөвлөгөө тасарсан, төвлөрсөн орлогыг ОНХС-ийн дансанд бүрэн шилжүүлээгүйгээс шалтгаалан сангийн эх үүсвэр дутагдах, төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх үндсэн нөхцөл болсон байна.

1.1.9. Сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ын эх үүсвэрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөтэй тулган баталгаажуулахад дараах сумд 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 123.3 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна. Үүнд:

- Баруунбүрэн сум 46.8 сая төгрөгөөр,
- Жавхлант сум 25.3 сая төгрөгөөр,
- Сүхбаатар сум 50.2 сая төгрөгөөр,
- Хүдэр сум 1.0 сая төгрөгөөр гэх мэт.

1.1.10. Тайлант онд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аймаг, сумдын ОНХС-ын дансанд дараах орлогуудыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-д тусгай зөвшөөрөл эзэмшигч "Чамин алт" ХХК-тай 2023 онд байгуулсан гэрээний дагуу /нийт 50.0 сая төгрөгийн/ 10.1 сая төгрөгийн,
- Орхонтуул сумын ОНХС-д "Мөнгөн нуруу" ХХК-аас 9.1 сая төгрөгийн хандив хүлээн авсан бол
- Сүхбаатар сумын ОНХС-д "Сэлэнгэ таван үндэс" ХХК-аас 7.0 сая төгрөгийн ШШГ-ийн орлого зэрэг нийт 26.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

1.1.11. Харин Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба нь аж ахуйн нэгжээс /"Ерөө Баянгол"/ өгсөн 2.5 сая төгрөгийн хандивын орлогыг ОНХС-ийн дансанд бус

нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.2.5³ дахь заалтыг зөрчсөн байна.

1.1.12. Сангийн яамнаас сумдын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд хийгдсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Алтанбулаг, Орхон, Сүхбаатар, Түшиг сумд нь 59-67 хувиар буюу хангалтгүй үнэлүүлсэн бөгөөд тайлант онд 411.4 сая төгрөгийн урамшуулал авах боломжийг алдсан байна

1.1.13. Аймаг, сумдын ОНХС-д бусад эх үүсвэрээс бүрдүүлэх орлого буюу Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁴-т заасан эх үүсвэрийг огт төлөвлөөгүй байна. Энэ нь ОНХС-ын эх үүсвэрийг бүрдүүлэхэд нөөцийг бүрэн ашиглахгүй байгаатай холбоотой байна. Цаашид ОНХС-гийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг судлах, МТТАТ-ыг төлөвлөсөн хэмжээнд төвлөрүүлэх, ОНХС-ын эх үүсвэрийг бүрэн бүрдүүлж, ажиллах шаардлагатай байна.

1.2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 4 төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

1.2.1. Аймаг, сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн хөрөнгө оруулалтын ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1⁵, 63.2⁶, 63.3⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5, 6, 7 дугаар зүйлд заасан байдаг.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулах, бүрэлдэхүүнийг томилохтой холбоотой дараах зөрчил илэрсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Тодруулбал:

- Баруунбүрэн, Жавхлант, Орхон, Түшиг, Шаамар зэрэг сумд нь 2023 оны 4-7 дугаар сард ажлын хэсгийг байгуулсан,
- Аймаг болон Баруунбүрэн, Ерөө, Орхон, Түшиг зэрэг сумд нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэд, нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулаагүй гэх мэт.

1.2.3. Аймаг, сумдын Засаг даргаас томилсон ажлын хэсэг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэд, олон нийтэд нээлттэй асуулга явуулж, давхардсан тоогоор 110,181 санал авсан байна. Нийт саналын 86.3 хувь буюу

³ 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

⁴ Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

⁵ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

⁶ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно


⁷ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

95,128 саналыг цаасаар, 12.8 хувь буюу 14,141 саналыг бүлгийн ярилцлагаар, 0.83 хувь буюу 912 саналыг цахимаар өгснөөс аймаг, суманд 42,478.8 сая төгрөгийн 343 ТАНХ батлагдаж, 185,505.9 сая төгрөгийн урьдчилсан төсөвт өртөгтэй 491 санал цуцлагдсан байна. /Дэлгэрэнгүйг судалгаа 10-аас харах/

1.2.4. ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2 дахь заалтын хүрээнд тулган баталгаажуулахад Зүүнбүрэн, Цагааннуур, Орхон, Шаамар зэрэг сумд нь хурлын ирцийг бүрэн бүрдүүлээгүй, ирцийг гарын үсгээр баталгаажуулаагүй бол Сайхан сум нь иргэдийн саналыг авч, эрэмбэлэгдээгүй 262.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 4 төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зөрчил илэрсэн. Тодруулбал:

- “Гүний худгийн насос худалдан авах”-19.9 сая төгрөгийн,
- “Спорт заал орчмын тохижилт” -58.0 сая төгрөгийн,
- “Малын худгийн усалгааны систем шинээр суурилуулах”-50.0 сая төгрөгийн,
- Малын худгийн усалгааны систем шинээр суурилуулах”-135.0 сая төгрөгийн гэх мэт.

1.2.5. Аудитын явцад ОНХС-ын үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтээс цахимаар авсан санал асуулгад хамрагдсан 659 иргэний 72.1 хувь нь 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн гэж хариулсан байна. Иргэдийн санал өгсөн байдал:



1.2.6. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2, 63.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сум нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, эрэмбэлж, үр дүнг нэгтгэхээр зохицуулсан байдаг.

1.2.7. Үүний хүрээнд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/300 дугаар захирамжаар томилон сумдаас ирүүлсэн нийт 107 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, эрэмбэлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

1.2.8. Аймгийн ОНХС: Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 16,304.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 70 төсөл, арга хэмжээг эцэслэн баталсны 7,987.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 8,317.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр эхлэх 51 төсөл арга хэмжээ байна.

1.2.9. Сумдын ОНХС: Сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 31,379.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 310 төсөл, арга хэмжээг эцэслэн баталснаас 4,944.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжсэн бол 26,435.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр эхлэх 275 төсөл арга хэмжээ байна.

1.2.10. Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр 47,684.5 сая төгрөгийн 380 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 27,706.2 сая төгрөгийг буюу 51.8 хувийг барилга байгууламж, 3,931.2 сая төгрөгийг буюу 8.2 хувийг машин, тоног төхөөрөмж, 14,348.0 сая төгрөгийг буюу 30.1 хувийг их засвар, тохижилт, 4,699.1 сая төгрөг буюу 9.9 хувийг бусад урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.2.11. Дээрхээс үзэхэд нийт ТАХ-ний 81.9 хувь буюу 39,054.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумдын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод тусгасан чиглэлтэй уялдаж байна.

1.2.12. Аймаг, сумдын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт 4,537.0 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр ИТХ-аар баталсан байна /Дэлгэрэнгүйг хавсралтад 2-д харуулав/. Үүнд:

- Аймгийн ОНХС: 6 төсөл арга хэмжээ, 1,656.8 сая төгрөг
- Сумдын ОНХС: 14 төсөл, арга хэмжээ, 2,880.2 сая төгрөг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2.13. ОНХС-ын чиг үүрэгт үл хамаарах 354.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй удирдлагын шинж чанартай дараах 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.3.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийг 4.2, 4.4, 4.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Ерөө сумын 113.1 сая төгрөгийн багийн байр барих,
- Мандал сумын 164.4 сая төгрөгийн хаягжуулалт,
- Түшиг сумын 56.8 сая төгрөгийн ЗДТГ-т автомашины граж барих,
- Орхон сумын 20.0 сая төгрөгийн Бэлэндалай багийн багийн Засаг даргын байр засварлах зэрэг.


БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 31.6 ХУВЬ НЬ ДУТУУ БОЛОН ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БУЮУ ТӨЛӨВЛӨСӨН ЗОРИЛТОД ТҮВШИНД БҮРЭН ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээний биелэлт, үр дүнг “Гэрээ дүгнэх маягт”-аар үнэлээгүй байна.

Аймгийн ОНХС:

2.1.1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 16,304.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээ /7,987.0 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 8,317.6 сая төгрөгийн 51 төсөл арга хэмжээ нь шинээр эхлэх/ баталснаас 8,536.7 сая төгрөгийн 53 төсөл арга хэмжээ бүрэн /гэрээний дүнгээр/, 3,397.2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ /гэрээний дүнгээр/ дутуу хэрэгжиж, 4,025.7 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг судалгаа 3-т харуулав./

Дүрслэл 3. Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.1.2. Өмнөх оноос шилжин хэрэгжих 1,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, шинээр хэрэгжих 8,317.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 зэрэг нийт 9,340.1 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 8,209.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг судалгаа 2-т харуулав./ Үүнд:

- 5,892.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 1,617.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар,
- 100.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах гэх мэт.

2.1.3. Тайлант онд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2⁸ дахь заалт болон аймгийн Онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийн дагуу 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дахин төлөвлөлтөд орсон барилгын буулгалтын ажил /Сүхбаатар сум/”-ыг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна.

2.1.4. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁹ дэх заалтын дагуу 200.0 сая төгрөгийн “Баяр наадмын зардал”-ыг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна.

2.1.5. Худалдан авах ажиллагааг тус бүр 2-10 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй болон шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул 716.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. Үүнд:

- ✓ *Соёлын төвийн барилгын засвар /Түшиг сум/ 178.3 сая төгрөг-10 удаа зохион байгуулаад, сүүлийн 2 тендерт оролцогч ирсэн боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй,*
- ✓ *Хамар давааны орчмын зам засвар /Мандал, Түнхэл тосгон / 278.5 сая төгрөг-5 удаа зохион байгуулаад оролцогч ирээгүй,*
- ✓ *Төрийн албан хаагчдын байрны дулааны шугам, цахилгааны шугам /Түшиг сум/ 260.0 сая төгрөг-2 удаа зохион байгуулаад оролцогч ирээгүй.*

2.1.6. Дээрх 3 төсөл, арга хэмжээнд нэг ч оролцогч ирээгүй байхад захиалагч тендер ирүүлээгүй шалтгааныг судалж, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах эсэх асуудлаар шийдвэр гаргаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

2.1.7. Худалдан авах ажиллагааны тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулж, худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

2.1.8. Аймгийн ОНӨГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.2¹¹-т заасны дагуу Сангийн яаманд цахим системээр хүргүүлсэн байна.

⁸ онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

⁹ Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно.

¹⁰ Тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй бол захиалагч тендер ирээгүй шалтгааныг судалж, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах эсэхийг шийдвэрлэнэ.”

¹¹ Энэ журмын 3.1-д заасан захиалагчийн тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана.

2.1.9. Төсвийн тодотголоор буюу аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор 37 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 302.7 сая төгрөгийн хэмнэлтийг гэрээний дүнгээр бууруулж, 4 төсөл арга хэмжээний батлагдсан төсвийг нэмэгдүүлэн баталж, санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3¹² дахь худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.1.10. Төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- "Сургуулийн их засвар /Мандал сум, 3-р сургууль/", "1-р сургуулийн их засвар /Сэлэнгэ, Мандал сум/ зэрэг 2 төсөл арга хэмжээний 18.2 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу хурлын тэмдэглэлгүйгээр олгосон,
- Тайлант онд нийлүүлэгдсэн автомашин, тээврийн хэрэгсэл, багш хөгжлийн төв, Соёлын төвийн тоног, төхөөрөмж, цэцэрлэгийн тоног төхөөрөмж зэрэг 1,724.9 сая төгрөгийн 17 ажлыг хүлээн авах комисс нь хөрөнгийн бүрэн бүтэн байдал, иж бүрдэл зэргийг нэр төрөл тус бүрээр тоо, ширхэг, техникийн үзүүлэлттэй тулгаж хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-д харуулав/.

Эдгээр нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.17¹³, 4.10.1.4¹⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.1.11. Өмнөх оноос шилжих "ЭМТ-ийн барилга /Цагааннуур сум /" ажлын 27.5 сая, "Гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг /Шаамар сумын Дулаанхаан тосгон/" ажлын 53.9 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн ИТХ-ын тогтоолд шилжих хөрөнгө оруулалтаар батлуулалгүй 2024 онд санхүүжүүлсэн байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2¹⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3.1¹⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.1.12. Тоног төхөөрөмж хүлээн авах комисс нь гүйцэтгэгчийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийг тоо, ширхэг техникийн үзүүлэлттэй тулгаж аваагүйгээс гүйцэтгэгч

¹² хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх.

¹³ 4.8.17. Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно;

¹⁴ захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн

¹⁵ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

¹⁶ ... төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална: 3.3.1.1.шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ;

компани нийт 12.4 сая төгрөгийн хөрөнгө дутуу нийлүүлсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:


- "Багш хөгжлийн төв /Ерөө, Бугант тосгон/"-ажлын гүйцэтгэгч БТИНК ХХК нь 11.4 сая төгрөгийн 15 үзүүлэлттэй суурин компьютер 5 ш, компьютерын ширээ 3ш, сандал 6ш тус тус дутуу нийлүүлсэн,
- "Сургуулийн багш хөгжлийн төв /Орхон сум/"-ын ажлын гүйцэтгэгч Прогресс интер медишн ХХК 1.0 сая төгрөгийн 2 бичгийн шүүгээ дутуу нийлүүлсэн.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.10.1.4¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Сумдын ОНХС:

2.1.13. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 31,379.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 310 төсөл, арга хэмжээ баталснаас 14,307.9 сая төгрөгийн 207 төсөл арга хэмжээ бүрэн /гэрээний дүнгээр/, 6,599.6 сая төгрөгийн 34 төсөл арга хэмжээ /гэрээний дүнгээр/ дутуу хэрэгжиж, 5,898.6 сая төгрөгийн 69 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав./

Дүрслэл 4. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх үүсвэр: Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.1.14. 2024 онд шинээр хэрэгжүүлэх 26,261.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 274 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 22,850.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 226 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд:

- 15,041.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 5,086.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 79 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,

¹⁷ захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, энэ журмын 9 болон 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана;

- 949.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар,
- 168.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг олон нийтийн оролцоотой худалдан авалтын аргаар,
- 1,605.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 99 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах гэх мэт.

2.1.15. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4¹⁸ дэх заалтын дагуу 8 сум нь 949.2 сая төгрөгийн “Баяр наадмын зардал”-ыг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна.

2.1.16. Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэснээс худалдан авах ажиллагаа оройтсон, зарим төсөл, арга хэмжээний зураг төсөв хийгдээгүй, төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээ нэмж батлагдсанаас худалдан авах ажиллагаа оройтсон, тендер зарлаад оролцогч ирээгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, зарим төсөл, арга хэмжээний батлагдсан төсөв бага байснаас цуцлагдсан, зарим төсөл, арга хэмжээний газрын зөвшөөрөл гараагүй, малын тоо толгойн албан татварын орлого дутуу төвлөрсөн зэрэг шалтгааны улмаас 3,411.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 48 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2.1.17. Гүйцэтгэгчийг сонгох харьцуулалтын аргаас зайлсхийж Ерөө, Зүүнбүрэн, Цагааннуур сум нь **194.5** сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹⁹, 31 дүгээр зүйлийн 31.1²⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Ерөө сум: Зөвлөх үйлчилгээний тендер зарлахгүйгээр “Бугант спорт заалны зураг төсвийн зардал”-ын ажилд 25.0 сая төгрөгийн гэрээ шууд байгуулсан,
- Зүүнбүрэн сум: Баяр наадмын зардалд батлагдсан төсвөөс харьцуулалтын аргаар тендер зарлалгүйгээр “ Ойн арга хэмжээний сэтгүүл” хэвлүүлэхэд 25.0 сая төгрөгийн, “Асар майхан худалдан авах”-д 34.5 сая төгрөгийн тус тус гэрээ шууд байгуулсан,
- Цагааннуур сум: Зөвлөх үйлчилгээний тендер зарлахгүйгээр “Хатуу хучилттай замын зураг төсөв”-ийн ажилд 80.0 сая төгрөгийн, “Үерийн далангийн зураг төсөв”-ийн ажилд 30.0 сая төгрөгийн гэрээ шууд байгуулсан.

2.1.18. Шаамар сумын 106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн албан хаагчдын байр худалдан авах” ажлын худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Төрийн албан хаагчдын байр худалдан авах” ажлын ХАА-г зохион байгуулах үнэлгээний хороо 2024 оны 03 дугаар сарын 12-нд байгуулагдсан боловч тендерийг 2024 оны 10 дугаар сарын 28-нд зарласан,
- Дээрх төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн ТШЗ 40.1-д “ шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ”, 40.1-д “ ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн 3 хувийн үнийн дүнтэй

¹⁸ Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно.

¹⁹ Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

²⁰ Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна:

гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.” гэж заасан боловч тендерт оролцогч “Эл Си Би” ХХК нь гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²¹, 48 дугаар зүйлийн 48.2.1²², 48.2.8²³, 50 дугаар зүйлийн 50.10²⁴ дахь заалтууд болон сумын Засаг даргын баталсан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус зөрчсөн байна.

2.1.19. Орхонтуул сум нь Рашаант тосгоны иргэдэд “Явуулын иргэний танхим”-ын үйлчилгээ үзүүлэх зориулалтаар авто машин худалдан авах” 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний хүрээнд Hiase маркийн автобусыг /2014 онд үйлдвэрлэгдэж, 2024 онд Монголд орж ирсэн зах зээлийн үнэ ойролцоогоор 55.0-62.0 сая төгрөг/ 68.3 сая төгрөгөөр буюу зах зээлийн үнээс зөрүүтэй худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.1.20. Дараах сумд нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 342.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Ерөө сумын 95.2 сая төгрөгийн багийн байр барих
- Мандал сумын 164.4 сая төгрөгийн хаягжуулалт,
- Түшиг сумын 62.6 сая төгрөгийн ЗДТГ-т автомашины граж барих,
- Орхон сумын 20.0 сая төгрөгийн Бэлэндалай багийн багийн Засаг даргын байр засварлах зэрэг.

2.1.21. Түшиг, Хушаат, Цагааннуур сум нь сумын ИТХ-аар батлагдсан төсвөөс 33.9 сая төгрөгөөр илүү дүнгээр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Түшиг сум нь “ЗДТГ-т автомашины граж барих” төсөл арга хэмжээнд ИТХ-аас батлагдсан төсвөөс 5.8 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон. Үүнд:

- Зохиогчийн хяналтын дүгнэлтгүйгээр зохиогчийн хяналтын зардалд 0.8 сая төгрөг,
- Зураг төсвийг хүлээж авсан актгүйгээр зураг төсвийн зардалд 5.0 сая төгрөг тус тус олгосон,

2. Хушаат сум нь “Биеийн тамирын талбайн тохижилт” төсөл арга хэмжээний гэрээний дүнд зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлыг тусгаагүйгээс батлагдсан төсвөөс 2.6 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон.

3. Цагааннуур сум нь “Явган хүний зам”-ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгохдоо захиалагчийн хяналтын зардлыг ИТХ-ын тогтоолд тусгаагүйгээс тогтоолын дүнгээс 2.5 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон.

²¹ Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

²² худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;

²³ энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;

²⁴ Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлон, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2²⁵, 41 дүгээр зүйлийн 41.2.2²⁶, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.4.12²⁷, 4.3.5.3²⁸ -д гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.1.22. Хушаат сум нь сумын ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй “Зураг төсөв хийлгэх”, “Бэлчээрт худаг гаргах” гэсэн 2 төсөл, арга хэмжээнд 23.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2 гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.1.23. Ерөө, Мандал сум нь төсвийн тодотголоор худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг өөр төсөл, арга хэмжээнд санхүүжүүлэхээр төлөвлөсөн, тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулсан зэрэг 147.2 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ерөө сум нь сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор 10 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 54.3 сая төгрөгийн хэмнэлтийг гэрээний дүнгээр бууруулж, шинээр 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, санхүүжүүлсэн,
- Мандал сум нь сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 152 дугаар тогтоолоор 4 төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх дүнг 92.9 сая төгрөгөөр бууруулж баталж, санхүүжүүлсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6²⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3³⁰ дахь гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.1.24. Төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Орхонтуул, Сайхан, Цагааннуур сумд нь хурлын тэмдэглэлгүйгээр 10 төсөл, арга хэмжээний магадлалгүй ажлын зардалд 19.9 сая төгрөг олгосон. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-д харуулав/
- Зүүнбүрэн, Цагааннуур сумд нь гэрээ байгуулсан ажлууд тогтоосон хугацаанд ашиглалтад ороогүй боловч гэрээний хугацаанд өөрчлөлт оруулаагүйгээс хугацаа хэтэрсэн 9 төсөл арга хэмжээнд 2.8 сая төгрөгийн алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5 -д харуулав./
- Цагааннуур сум нь “Халуун усны засвар”, “1.3-р багийн мал угаалгын ванн” гэсэн 2 төсөл, арга хэмжээний 2.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үе

²⁵ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;

²⁶ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

²⁷ зохиогчийн хяналтын зардал олгох тохиолдолд зохиогчийн хяналтын гэрээ, зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлт болон тайлан;

²⁸ тухайн төслийн зураг төсвийн зардлыг олгох тохиолдолд зураг төсвийн гэрээ, зураг төсөв хүлээлцсэн акт;

²⁹ тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

³⁰ “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”

шатны хяналт хэрэгжүүлсэн тайлан, захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлтгүйгээр олгосон,

- Баруунбүрэн сум нь “Наадмын талбайн асруудыг засварлах” ажлын гэрээ дүгнэсэн болон хүлээн авсан актад сумын Засаг даргын 2024 оны 07 сарын А/73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг бус зөвхөн Засаг дарга Ц.Сэлэнгэ гарын үсэг зурж хүлээн авсан байхад 126.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- Жавхлант сум нь 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн албан хаагчийн байр худалдан авах” төсөл арга хэмжээний хүрээнд иргэн Ж.Отгонбаатараас 4 айл амьдрах боломжтой байшин худалдан авсан бөгөөд газрын гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй.

Эдгээр нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.7.10³¹, 4.8.17³², 4.10.1.2³³, 4.10.1.3³⁴, 5.5.1³⁵-т заасныг зөрчсөн байна.

2.1.25. 9 сумд нь гэрээний биелэлт, үр дүнг “Гэрээ дүгнэх маягт”-аар үнэлж, баталгаажуулалгүйгээр нийт 1,799.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээнд 1,657.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. *Дэлгэрэнгүйг хавсралт 6-д харуулав/*

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29³⁶-д заасныг зөрчсөн байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн 79 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй буюу төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.

2.2.1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т “ ... ОНХС-ийн хөрөнгөөр ... барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх **хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ**” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.2.2. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 47,684.5 сая төгрөгийн 380 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 260 төсөл, арга хэмжээ буюу 68.4 хувь нь

³¹ Гэрээний алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд тусгах бөгөөд алданги үүссэн тохиолдолд энэ талаар санхүүжилтийн хүсэлтийн албан бичиг, гүйцэтгэлийн баримт бичигт тусгаасан байна;

³² Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зурга төсөлд тусгаадаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно;

³³ захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

³⁴ их засварын ажлыг хийж дуусаад улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана;

³⁵ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

³⁶ Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ;

бүрэн хэрэгжсэн, 41 төсөл, арга хэмжээ буюу 10.8 хувь нь дутуу хэрэгжсэн, 79 төсөл, арга хэмжээ буюу 20.8 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа /хувиар/

№	Аймаг, сум	ИТХ-аар батлагдсан		Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
		Тоо	Дүн	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Алтанбулаг	8	564.5	7	87.5	1	12.5		
2	Баруунбүрэн	22	951.3	10	45.5	7	31.8	5	22.7
3	Баянгол	22	3,224.9	18	81.8	3	13.6	1	4.5
4	Ерөө	26	4,618.8	18	69.2	5	19.2	3	11.5
5	Жавхлант	16	484.5	14	87.4	1	6.3	1	6.3
6	Зүүнбүрэн	14	626.3	9	64.3			5	35.7
7	Мандал	29	7,588.9	10	34.5	8	27.6	11	37.9
8	Орхон	14	494.1	14	100				
9	Орхонтуул	24	2,223.5	15	62.5	2	8.3	7	29.2
10	Сайхан	16	1,249.0	11	68.8	1	6.3	4	25.0
11	Сант	21	760.6	14	66.7	1	4.7	6	28.6
12	Сүхбаатар	14	1,186.0	11	78.6	1	7.1	2	14.3
13	Түшиг	21	912.5	11	52.4	1	4.8	9	42.8
14	Хушаат	23	672.7	21	91.3			2	8.7
15	Хүдэр	3	3,736.2	1	33.3	1	33.3	1	33.4
16	Цагааннуур	32	1,695.5	20	62.5	2	6.2	10	31.3
17	Шаамар	5	390.4	3	60.0			2	40.0
	Сумын дүн	310	31,379.9	207	66.7	34	11	69	22.3
18	Аймгийн ОНХС	70	16,304.6	53	75.7	7	10.0	10	14.3
	Нийт дүн	380	47,684.5	260	68.4	41	10.8	79	20.8

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.2.3. Аудитын дүнгээс харахад төсөл, арга хэмжээнүүд нь дор дурдсан шалтгааны улмаас дутуу болон огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Иргэдийн саналгүй, зураг төсөв, тооцоо судалгаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан,
- Худалдан авах ажиллагааг оройтуулсан, ажил гүйцэтгэх боломжгүй хугацаанд гэрээ байгуулсан,
- Худалдан авах ажиллагааг давтан зарласан боловч оролцогч санал ирүүлээгүй,
- Зарим төсөл, арга хэмжээний батлагдсан төсөв бага байснаас,
- Зарим төсөл, арга хэмжээний газрын зөвшөөрөл гараагүйгээс,
- Төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээ нэмж батлагдсанаас худалдан авах ажиллагаа оройтсон,
- Малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйгээс санхүүжилт хүрэлцэхгүй байх гэх мэт.

2.2.4. ОНХС-ийн хөрөнгийг бүс нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн явган хүний зам, сайжруулсан болон хатуу хучилттай зам тавих, засварлах, гүүрийн байгууламж барьж байгуулах /8,331.6 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээ/, орчны тохижилт, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх /1,647.9 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ/, хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулж, тохижуулах /1,555.9 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ/, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, цахилгаан, дулааны шугамд холбох ажилд /4,083.9 сая төгрөгийн 18 төсөл арга/, гэрэлтүүлэг, камержуулалтын ажилд /4,173.7 сая төгрөгийн 31 төсөл арга/ түлхүү байдлаар төлөвлөж зарцуулсан нь иргэдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, орон нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа сайн талууд оршиж байна.



3х3 сагсан бөмбөгийн талбай /Сүхбаатар, Мандал сум/
100.0 сая төгрөг



Тоглоомын талбай /Жавхлант сум/
97.6 сая төгрөг



Тоглоомын талбай барих /Ерөө сум/ 259.8 сая төгрөг

2.2.5. Нөгөө талаас ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь сангийн мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой соёлын байгууллагад студийн тоног төхөөрөмж, хөгжим хэрэгсэл, лед дэлгэц худалдан авах, сумын эрүүл мэндийн төвд эхо аппарат, сургууль, цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах, багш хөгжлийн төвийн тоног, төхөөрөмж, засвар зэрэг 15 төсөл, арга хэмжээнд 510.2 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэт жижиглэсэн буюу 1.0-20.0 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй улсын төсвийн байгууллагын хөгжим, хувцас, гэрэлтүүлэг, лед дэлгэц, тоног төхөөрөмж, урсгал засвар, худаг, тоглоомын талбай, явган хүний зам, малын чанарыг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, малчдын сургалт зэрэг 107 төсөл, арга хэмжээнд **1,604.9** сая төгрөгийг зарцуулсан байна.

2.2.6. ОНХС-ийн төлөвлөгөөнд хэдийгээр тодорхой хэмжээний иргэдийн эрх ашигт нийцсэн боловч тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих бус төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 3 төсөл, арга хэмжээг 751.6 сая төгрөгөөр тусгаж, хэрэгжүүлсэн байна.

2.2.7. 5 сум нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг

тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй, баримт материалыг нэгтгээгүй байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгүүд нь бүрэн ашиглалтад ороогүй байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс нь журмын дагуу ажиллаж, хүлээн аваагүйгээс зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийн дагуу бараа, тоног төхөөрөмжийг бүрэн хүлээлгэн өгөөгүйн улмаас 239.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ бүрэн ашиглалтад ороогүй байна. Үүнд:

- Баруунбүрэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 126.9 сая төгрөгийн гэрээтэй “Наадмын талбайн асруудыг засварлах”-ийн ажлыг ажил хүлээн авах комисс бус тус сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Сэлэнгэ нь хүлээн авсан гэх боловч энэ ажлын хүрээнд “И Жи Өү” ХХК-иас нийлүүлэгдэх ёстой 39.5 сая төгрөгийн өртөгтэй 8 ханатай бүрэн сийлбэртэй иж бүрэн 1 ширхэг монгол гэр, 4 ширхэг асар майхан нь бодитоор байхгүй, нягтлан бодох бүртгэл тайланд тусгаадаагүй,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 47.4 сая төгрөгийн гэрээтэй “Багш хөгжлийн төв /Ерөө, Бугант тосгон/” ажлын хүлээн авах комисс нь гүйцэтгэгч БТИНК ХХК 15 үзүүлэлттэй 5 ширхэг суурин компьютер, 3 ширхэг компьютерын ширээ, 6 ширхэг сандал тус тус дутуу нийлүүлсэн байхад комиссын актаар хүлээн авсан,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 64.9 сая төгрөгийн гэрээтэй “Сургуулийн багш хөгжлийн төв /Орхон сум/”-ын ажлын хүлээн авах комисс нь гүйцэтгэгч Прогресс интер медишн ХХК 2 ширхэг шүүгээ дутуу нийлүүлсэн байхад комиссын актаар хүлээн авсан.

2.3.3. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 242.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулаагүй байгаа нь хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна. Үүнд:

- Мандал сумын Хэрх тосгонд хэрэгжсэн 43.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Спорт заалны тоног төхөөрөмж”-ийг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээж авсан боловч заалны засвар хийгээгүйн улмаас ашиглаж эхлээгүй,
- Мандал сумын Хэрх тосгонд хэрэгжсэн 158.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Камержуулалт”-ийн ажил нь Мандал сумын Цагдаагийн газарт хүлээлгэн өгөх учраас энэ жил тус суманд хийгдэж байгаа камержуулалтын ажилтай хамт нэгдсэн холболт хийж, хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байгаа,
- Сүхбаатар суманд хэрэгжсэн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоо худалдан борлуулах цэг” нь халаалтгүй учраас 2025 оны 06 дугаар сараас ашиглалтад орсон.

2.3.4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийн харуул хамгаалалт, ашиглалт, урсгал зардал тодорхой бус байгаагаас эдгээр хөрөнгүүд эзэнгүйдэх, эвдэрч, гэмтэх эрсдэлтэй байна.

БҮЛЭГ 3. АЙМАГ, СУМДЫН ЗДТГ НЬ ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ, ҮР ДҮНГ ЖУРМЫН ДАГУУ НЭГТГЭЖ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.1.1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

3.1.2. Аймгийн болон Мандал, Сайхан сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй, Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Орхонтуул, Сант, Хушаат сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь хяналтыг дутуу хэрэгжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг удалгаа 5-аас харах/

3.1.3. Харин хяналт хэрэгжүүлсэн сумдын ИТХ-ын дэргэдэх хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч, эрэмбэлсэн эсэх, багийн ИТХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлыг хяналтад хамруулалгүйгээр зөвхөн хэрэгжилт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан эсэхийг хамруулсан байна.

3.1.4. Аймаг, сумын ЗДТГ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.5³⁷ дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ёстой боловч огт хэрэгжүүлээгүй байна.

3.1.5. Баянгол, Ерөө, Мандал сумын ЗДТГ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгүйгээр зөвхөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд л хяналт хэрэгжүүлсэн байна.

3.1.6. Тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт огт хийгдээгүй байна.

3.1.7. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй боловч 17 сумаас 9 сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа,

³⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

санхүүжилт, зарцуулалтад хяналт шалгалт хийж, 6,116.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 18 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.8. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 7 сум нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт **519.8** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **10** төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй нь Барилгын тухай хуулийн 37.2³⁸ дахь, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2 ³⁹, 3.9 ⁴⁰ дэх заалтуудыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг судалгаа 5-д харуулав./ Үүнд:

3.1.9. Захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй зөрчил өмнөх оноос 2.6 дахин өссөн нь тус хяналтыг хэрэгжүүлдэг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын захирал нь 2024 оны 8 сарын 1-ээс солигдож, үүрэг гүйцэтгэгч томилогдоогүйгээс голлон шалтгаалсан байна.

3.1.10. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, аймаг, сумдын дүнгээр нийт 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 11,964.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,274.0 сая төгрөгийн 28 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд биелэлтийг үнэлэхэд акт 100 хувь, албан шаардлага 50.0 хувь, зөвлөмж 76.5 хувь тус тус биелсэн байна.

3.1.11. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй тайлант онд дараах алдаа зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- *Зүүнбүрэн сум нь зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн, 1 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,*
- *Орхонтуул сум нь зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн, магадалшгүй ажлын актгүй зардлыг олгосон,*
- *Сайхан сум нь зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн, захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй,*
- *Түшиг сум нь зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн,*
- *Цагааннуур сум нь төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулаагүй байхад алданги тооцоогүй,*
- *Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн, магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр олгосон, төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй.*

3.1.12. Дээрх зөрчлүүдийг давтан гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах боломжгүй ажлаас чөлөөлөгдсөн тул зөрчлийг таслан

³⁸ Захиалагч барилгын ажлын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

³⁹ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

⁴⁰ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

3.2 Аймаг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу нэгтгэн тайлагнаж хүргүүлээгүй байна.

3.2.1. ОНХС-ийн 2024 оны хэрэгжилтийн тайланг 2 сум албан бичгээр, 15 сум цахимаар аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүлсэн боловч тус хэлтэс нь ирүүлсэн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг зөрчсөн байна.

3.2.2. Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яамны ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтыг зөрчсөн байна.

3.2.3. Аймаг, сумдын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 16,156.1 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудын үндсэн хөрөнгөд, 543.8 сая төгрөгийг бараа материалын дансанд тус тус бүртгэсэн бол баяр наадмын зардал, малын үзлэг ангилалт, сургалт, сурталчилгаа болон нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орон сууцны засвар гэх мэт нийт 3,174.5 сая төгрөгийг урсгал зардлаар тайлагнасан байна.

3.2.4. Аудитаар нийт 1,837.6 сая төгрөгийн дараах хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд орлогоор бүртгэж, тайлагнаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхээр заасныг зөрчсөн байна. Тодруулбал:

1. Аймгийн ОНХС:

- Сайхан сумын хатуу хучилттай авто замын 592.8 сая төгрөгийн,
- Орхонтуул сумын Рашаант тосгоны инженерийн шугамын ажлын 291.2 сая төгрөгийн,
- Сүхбаатар, Мандал сумын Хэрх тосгоны 3*3 сагсан бөмбөгийн талбайн 99.8 сая төгрөгийн,
- Мандал сумын 3 дугаар сургуулийн их засварын ажлын 44.6 сая төгрөгийн зэрэг нийт **1,778.4 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ.**

2. Сумын ОНХС:


- Баруунбүрэн сумын “Наадмын талбайн асар, майхан” 39.5 сая төгрөгийн,
- Сүхбаатар сумын “Өвс тэжээлийн нөөц бэлтгэх” 4.7 сая төгрөгийн,
- Хушаат сумын “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх” 15.0 сая төгрөгийн зэрэг нийт **59.2 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ гэх мэт.**

3.2.5. Энэ нь ОНХС-ийн журмын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүйгээс төрийн өмч хөрөнгө алдагдах, эзэнгүйдэх эрсдэл үүсгэж байна.

3.2.6. Аудитын явцад Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аймаг нь 16,304.6 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээг бүрэн оруулсан байна.
- 17 сум нь 27,096.5 сая төгрөгийн 268 төсөл арга хэмжээг бүрэн, 2 сум нь 2,065.2 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг дутуу, 8 сум нь 2,218.2 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээний мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 5. Удирдлагын мэдээллийн системд огт байршуулаагүй мэдээлэл /сая төгрөг/



Эх үүсвэр: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

3.2.7. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн талаар УМС-д мэдээллийг төсөл, арга хэмжээ бүрээр мэдээллийг оруулсан хэдий ч доторх мэдээллийг задалж үзэхэд бүрэн оруулаагүй буюу олгосон санхүүжилт, гүйцэтгэл болон хяналтын мэдээллийг дутуу мэдээлж байгаа нь иргэд, олон нийт үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

3.2.8. Аудитын явцад иргэд, олон нийтээс авсан санал асуулгаар ОНХС-ийн "Удирдлагын мэдээллийн систем"-ээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ? гэсэн асуулгад хамрагдсан 653 иргэний 42.3 хувь нь "Мэдээлэл авдаггүй", 18.7 хувь нь "Сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой", 24.5 хувь нь "Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой", 13.6 хувь нь "Худалдан авах ажиллагаатай холбоотой" гэж хариулсан байна.

3.2.9. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих буй төсөл арга хэмжээний явцад танд мэдээлэл өгөх, тайлагнах үйл явц хангалттай байсан уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 652 иргэний 36.8 хувь нь хангалтгүй, 35.4 хувь нь тийм, 27.8 хувь нь үгүй гэсэн хариулт өгсөн байна.

3.2.10. Үүнээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэх зорилготой уг цахим системийн ашиглалт хангалтгүй харагдаж байгаа бөгөөд иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажил дутмаг, иргэдийн идэвх сул байна.

3.2.11. Сангийн яам нь удирдлагын мэдээллийн системийн “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” цэсээр сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг 59.0-87.0 хувьтай үнэлүүлж, сумын дунджаар 75 хувьтай гарсан байна. Тодруулбал:

- Алтанбулаг, Орхон, Сүхбаатар, Түшиг сумд 59-67 хувиар,
- Баруунбүрэн, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Шаамар сумд 71-79 хувиар,
- Мандал, Сант, Хүдэр, Хушаат, Баянгол сумд 80-87 хувиар тус тус үнэлүүлсэн байна.

3.2.12. Цаашид дээрх сумд нь удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг тухай бүр, бүрэн оруулж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгтэй.

3.2.13. Аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу аймаг, сумд нь 2024 оны ОНХС-ийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн мэдээллийг ТЕЗ-ийн цахим хуудаст тус сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлбэл зохих 2 төрлийн 13 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Баруунбүрэн, Мандал, Сайхан, Сант, Сүхбаатар сумд нь ОНХС-ийн тусдаа хуудсыг хөтлөлөгүйгээр ТТЗ-ийн цахим хуудаст тус сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлбэл зохих 2 төрлийн нийт 65 мэдээлэл байршуулахаас 62 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 1 мэдээллийг мэдээлээгүй байна. /Дээрх сумд нь 2025 оноос ОНХС-ийн тусдаа цахим хуудас үүсгэн хөтөлж эхэлсэн байна./
- 12 сумын ОНХС-ийн мэдээлбэл зохих нийт 2051 мэдээллээс 1837 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож, 122 мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн бол 22 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Үүнээс харахад шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байгаа хэдий ч оруулсан мэдээллийг тулган баталгаажуулахад зөрүүтэй болон мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэх мэдээлэл байхгүй зэргээр буруу мэдээлж байгаа зөрчил нийт зөрчлийн 6 хувийг эзэлж байна.

Иймд ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлэхээс гадна үнэн зөв мэдээлж байх шаардлагатай байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар аймаг, сумдын дүнгээр нийт 14,339.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 51.9 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 10,295.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 3,992.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. */Дэлгэрэнгүйг судалгаа 6-д харуулав. /*

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 983.9 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.
2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 4 төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээний биелэлт, үр дүнг “Гэрээ дүгнэх маягт”-аар үнэлээгүй байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн 79 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй буюу төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгүүд нь бүрэн ашиглалтад ороогүй байна.
6. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
7. Аймаг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу нэгтгэн тайлагнаж хүргүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт хийж, үр дүнг хэлэлцэж, шийдвэрлэх.
2. Төсвийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй төсөл, арга хэмжээг ОНХС -ийн төлөвлөгөөнд тусгаж, батлахгүй байх.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. Жилийн эцсийн малын тоонд үндэслэн МТТАТ-ын орлогыг бодитоор төлөвлөж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг ОНХС-ийн дансанд бүрэн шилжүүлэх.
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах замаар төлөвлөсөн төсөл арга хэмжээг тухайн жилд нь багтаан ашиглалтад оруулах.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

3. Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийг хангуулах, хариуцлага тооцох замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх.
4. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг цахим системд ил тод нээлттэй мэдээлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Б.НАРАНЦЭЦЭГ